



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/472

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жаргалант сумын Цамбагарав багийн Заны 1 дүгээр гудамжны 111 тоотод байрлах худалдаа, үйлчилгээний зориулалттай Пүрэвдоржийн Хишигбаяр /ПЮ72112665/-ийн эзэмшлийн 208 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Пүрэвдоржийн Хишигжаргал /ПЮ75071768/-д 14 жилийн хугацаагаар,

2.Жаргалант сумын Хайрхан багийн Шинэ суурьшлын бүсэд байрлах 5-8 давхар орон нийтийн сууцны зориулалттай “Би Эм Жи Юу” ХХК /5995051/-ийн эзэмшлийн 6000 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Тэрбишийн Оюунцэцэг /ПЮ75112661/-д 2 жилийн хугацаагаар,

3.Жаргалант сумын Магсаржав багийн Амарсанаагийн 6 дугаар гудамжны 602 тоотод байрлах зочид буудлын зориулалттай Магсарын Түвдэндорж /ПЭ64120718/-ийн эзэмшлийн 1375 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу “Талын буудал” ХХК /6176801/-д 14 жилийн хугацаагаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

4.Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлэн авч, газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг дээрх иргэнд үүрэг болгосугай.

5.Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-т даалгасугай.



ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ